

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2023/04/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Архангай аймаг 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Бизкон аудит ХХК Архангай дахь салбар Утас: 85116555 Цахим хаяг: ankha964@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Материаллаг байдал.....	8
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
4.1 Байгууллагын үйл ажилагаа	9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	9
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
5.1 Шилэн дансны мэдээлэл	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Залруулсан алдаа.....	
8.2 Төлбөрийн акт.....	
8.3 Албан шаардлага.....	
8.4 Зөвлөмж.....	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж Ахуй Нэгжийн Орлогын Албан Татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

1. Аудитын санал дүгнэлт


**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

“АРХАНГАЙ АЗЗА” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ю.ГАНЗОРИГ
ТАНАА

2023.02.16 № 64
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Архангай АЗЗА ТӨХК-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Архангай АЗЗА ТӨХК-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цулуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Архангай АЗЗА ТӨХК нь 2009 онд олгогдсон Кувейтийн сангийн хөнгөлөлттэй зээлийн 198.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

ТӨБЗГ-ын 2021 оны 12 сарын 23 ний 657 тоот тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Бусад асуудал

Архангай АЗЗА ТӨХК тайлант онд 13 зорилтын хүрээнд 11 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлийг 97.8 хувьтай гэж тайлагнасан байна.

Бусад мэдээлэл

Архангай АЗЗА ТӨХК нь замын сангийн хөрөнгөөр улсын чанартай замын засвар арчлалтын ажлыг хариуцан гүйцэтгэж, 2022 онд 1,531.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,528.4 сая төгрөгийн зардал гарган, 3.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	273,581,656.94	8,003,130.33
1.1.2. Дансны авлага	47,935,767.80	1.00
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	12,669,647.52	24,782,731.19
1.1.6.Бара материал	160,266,563.70	566,473,831.35
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	494,453,635.96	599,259,692.87
1.2.1 Үндсэн хөрөнгө	889,365,833.52	831,041,444.45
1.2.2 Биет бус хөрөнгө	27,293,600.00	47,341,600.00
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	916,659,433.52	878,383,044.45
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,411,113,069.48	1,477,642,737.32
2.1.1.1 Дансны өглөг	0.00	53,156,631.27
2.1.1.3 Татварын өр	866,337.00	1.00
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	0.00	840,596.00
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	866,337.00	53,997,227.27
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	198,657,551.00	198,657,551.00
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	198,657,551.00	198,657,551.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	199,523,888.00	252,654,778.27
2.3 Эздийн өмч	951,290,586.80	971,338,586.80
2.3.1 Төрийн	951,290,586.80	971,338,586.80
2.3.4 Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5 Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	105,238,307.65	105,238,307.65
2.3.7 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00
2.3.9 Хуримтлагдсан ашиг	155,060,287.04	148,411,064.60
2.3.10	0.00	0.00
2.3.11 Эздийн өмчийн дүн	1,211,589,181.49	1,224,987,959.05
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,411,113,069.49	1,477,642,737.32

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	1,285,442,670.91	1,531,506,413.21
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,048,366,598.24	1,230,990,804.13
3. Нийт ашиг (алдагдал)	237,076,072.67	300,515,609.08
10. Ерөнхий ба удирдлагын зардал	194,388,329.81	238,244,269.22
12. Бусад зардал	21,174,081.80	58,881,587.01
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	21,513,661.06	3,389,752.85
19. Орлогын татварын зардал	2,151,366.11	338,975.29
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	19,362,294.95	3,050,777.56
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	19,362,294.95	3,050,777.56
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	19,362,294.95	3,050,777.56

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	951,290,586.80	105,238,307.65	155,060,287.04	1,211,589,181.49
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			3,050,777.56	3,050,777.56
6	Өмчид гарсан өөрчлөлт	20,048,000.00		-9,700,000.00	-9,700,000.00
9	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	971,338,586.80	105,238,307.65	148,411,064.60	1,224,987,959.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,326,526,861.00	1,667,104,998.80
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	59,273,309.00	4,970,000.00
Бусад мөнгөн орлого	1,267,253,552.00	1,662,134,998.80
1.2 Мөнгөн зарлагын дүн	1,365,633,512.78	1,922,983,525.41
Ажиллагчдад төлсөн	325,557,745.00	384,025,251.00
Нийгмийн даатгалын байгуулгад төлсөн	114,565,137.52	131,074,041.65
Бараа материал худалдан авахад төлсөн	481,066,841.36	870,945,640.45

Ашиглалтын зардалд төлсөн	352,000.00	
Татварын байгуулгад төлсөн	112,323,019.90	123,502,411.71
Бусад мөнгөн зарлага	331,768,769.00	413,436,180.60
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(39,106,651.78)	(255,878,526.61)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	-18,190,000.00
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(19,146,690.00)	(9,700,000.00)
Мөнгөн зарлагын дүн	19,146,690.00	9,700,000.00
Төлсөн ногдол ашиг	19,146,690.00	9,700,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(19,146,690.00)	(9,700,000.00)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(58,253,341.78)	(265,573,126.61)
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	331,834,998.72	273,581,656.94
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	273,581,656.94	8,003,130.33

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	х/нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны	
				төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт				
	а/Гол нэр төрлөөр	биет	282.9	282.9	318
2	Нийт орлого	м.төг	1,285,442.7	1,390,909.0	1,531,506.4
Үүнээс	а/Улсын чанартай зам засвар арчлалтын ажил	м.төг	1,139,693.7	1,272,727.0	1,510,552.8
	б/Орон нутгийн чанартай зам гүүрийн ажил	м.төг	88,640.6	90,909.0	-
	в/Бусад	м.төг	57,108.4	27,273.0	20,953.6
3	Нийт зардал	м.төг	1,263,929.0	1,363,090.8	1,528,110.9
	Үүнээс удирдлагын зардал	м.төг	194,388.3	245,866.4	238,244.2
4	Татварын өмнөх ашиг	м.төг	21,513.7	27,818.2	3,389.7
5	Цэвэр ашиг/алдагдал/	м.төг	19,362.3	25,036.4	3,050.7
6	Төсвийн нийт төлбөр	м.төг	225,639.6	262,056.8	250,122.8
6.1	а/Орлогын татвар	м.төг	2,151.4	2,781.8	338.9
6.2	б/НӨАТ	м.төг	73,910.1	89,479.4	76,976.0
6.3	в/НДШ	м.төг	114,565.1	121,450.0	131,074.0
6.4	г/ХХОАТ	м.төг	31,876.6	45,816.2	38,510.3
6.5	д/ҮХЭХАТ	м.төг	1,306.8	1,306.8	1,306.8
6.6	е/Гаалийн татвар	м.төг	-	-	-

6.7	ё/Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	1,239.2	1,163.2	1,163.2
6.8	ж/Бусад татвар	м.төг	590.4	90.4	753.0
7	Төрийн өмчийн ноогдол ашиг	м.төг	12,115.9	11,722.7	9,700.0
8	Нийт ажиллагсдын тоо	м.төг	36	37	37
9	Нийт цалингийн сан	м.төг	407,355.7	492,759.9	515,773.1
10	Нэг ажилтны дундаж цалин	м.төг	943.0	1,109.8	1,109.5
11	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.98	0.98	0.99
12	Хөрөнгө оруулалт	м.төг	25,054.9	68,000.0	10,000.0
13	Нийт авлага	м.төг	60,605.4	12,931.9	24,782.7
	Үүнээс: найдваргүй	м.төг	-	-	-
14	Нийт өглөг	м.төг	199,523.8	200,700.0	252,654.7
	Үүнээс: богино хугацаат өр төлбөр	м.төг	866.3	2,042.5	53,997.2
	Урт хугацаат өр төлбөр		198,657.5	198,657.5	198,657.5

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар 9,700.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрсэн, 2022 оны төрийн өмчийн ноогдол ашигт төлсөн төлбөрийг эздийн өмчийг бууруулж бичилт хийснийг өмнөх үеийн үр дүнг бууруулж залрууллаа.

Нийт 2,856.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,856.0 мянган төгрөгт 3 төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Албан томилолтын зардлыг анхан шатны баримтаар тулган шалгахад томилолтоор ажилласан хоногийг тооцохдоо явсан, ирсэн зам хоногийг нэг өдөрт тооцож хасалт хийлгүй томилолтын зардлыг илүү олгосон 1,863.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9.3-д "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.", Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.1.2 Тус байгууллагын захирлын гар утасны төлбөрт байгууллагаас 380.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д "гар утасны зардал" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.1.3 Удирдлагын тушаал шийдвэргүй 613.0 төгрөгийн хоол, буудлын зардал гаргасан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх, 4.2.1. зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах; гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Бэлэн мөнгө кассаар зарцуулалт хийсэнтэй холбоотой асуудлаар

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: мөнгөн хөрөнгөнд тавигдах хяналт алдагдах эрсдлийг үүсгэх, мөн компаний мөрдөж байгаа хууль, дүрэм, журамд бэлэн мөнгө хадгалах, зарцуулахтай холбоотой эрх зүйн баримт бичиг байхгүй гэсэн зөрчил илэрсэн.

Өгсөн зөвлөмж: Мөнгөн кассын ажиллагааны журам боловсруулж мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Архангай-АЗЗА ТӨХК	1	9,700.0					1	9,700.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Архангай-АЗЗА ТӨХК	4	2,856.0	3	2,856.0	-	-	1	-	-	-	-	-

